

UCS 1204B:2025

ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ГАДНА ОРЧИН




Хүүхдийн зуслангийн гадна орчинд тавигдах
ерөнхий шаардлага

ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ГАДНА ОРЧИН

Хүүхдийн зуслангийн гадна орчинд тавигдах
ерөнхий шаардлага

*Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 25/08-р тогтоолоор батлав.*



ГАРЧИГ

1. Хамрах хүрээ	5
2. Нэр томъёоны тодорхойлолт	5
3. Норматив ишлэл.....	6
4. Хүүхдийн зуслангийн гадна орчны ерөнхий шаардлага.....	6
5. Хүүхдийн байрлах байранд тавих шаардлага.....	13
6. Нийтийн ариун цэврийн байгууламж	14
7. Хог хаягдлын менежмент ангилан ялгалт	14
8. Аюулгүй байдлын ерөнхий шаардлага	15
9. Мэдээллийн самбар, анхааруулах тэмдэг, тэмдэглэгээ	18
10. Бохир усны инженерийн байгууламж, цэвэрлэсэн бохир усанд тавих стандарт шаардлага.....	19
11. Үерээс хамгаалах байгууламж болон хур тундасны ус цуглуулж үр ашигтай хэрэглэх байгууламж.....	19
12. Бие даасан цахилгаан хангамж.....	20
13. Бие даасан ус хангамж.....	20
14. Хүүхдийн зуслангийн стандартын шалгах хуудас.....	22
Ашигласан материалын жагсаалт.....	23

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Ерөнхий төлөвлөлт	6
Зураг 2. Ерөнхий төлөвлөлт харагдах байдал	7
Зураг 4. Хүртээмжтэй зогсоолын хэмжээ.....	9
Зураг 5. Хүүхдийн тоглоомын талбайн харагдах байдал	9
Зураг 6. Спортын талбайн харагдах байдал.....	10
Зураг 7. Хүүхдийн зуслангийн хашааны төрөл	10
Зураг 8. Дагуу налуу, хөндлөн хэвгий	11
Зураг 9. Гэрэлтүүлэг хоорондын зай болон гэрлийг суурилуулах	11
Зураг 10. Гадна гэрэлтүүлгийн харагдах байдал	12
Зураг 11. Хяналтын камерын дэлгэц	12
Зураг 12. Хяналтын постны харагдах байдал	13
Зураг 13. Хүүхдийн байрлах байр	13
Зураг 14. Нийтийн ариун цэврийн байгууламжийн харагдах байдал	14
Зураг 15. Хогийн сав.....	15
Зураг 16. Хог хаягдал түр хадгалах цэг.....	15
Зураг 17. Галын хорыг нүдэнд харагдахуйц газар байрлуулна	16
Зураг 18. Галын аюулгүй байдлыг хангасан байдал галын дохиолол.....	16
Зураг 19. Галын наадам хийх талбай.....	17

Зураг 20. Галын аюулгүй байдлын тэмдэг тэмдэглэгээ.....	17
Зураг 21. Бүхээгтэй суурин телефон утас	18
Зураг 22. Мэдээллийн самбар, анхааруулах тэмдэг, тэмдэглэгээ	18
Зураг 23. Үерээс хамгаалах байгууламж	19
Зураг 24. Ундны усны эх үүсвэрийг хамгаалахдаа дээрх нөлөөллийг тооцоолох.....	21

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Цахилгаан шугам сүлжээний хамгаалалтын бүс	20
Хүснэгт 2. Шалгах хуудас	22



НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2025 оны 01 сарын 24 өдөр

Дугаар 25/bs

Улаанбаатар хот

Худалдаа үйлчилгээний газрын гадна
орчинд хамаарах хотын стандартыг
батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.15 дахь заалт, 35 дугаар зүйлийн 35.1.13 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Монгол улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалт, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 10¹ дүгээр зүйлийн 10¹.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Нийслэлийн иргэдийн эрүүл аюулгүй, амьдрах эрхийг хангахад чиглэсэн “Худалдаа үйлчилгээний газрын гадна орчин” бүлэгт хамаарах дор дурдсан хотын стандартуудыг хавсралтаар баталсугай.

1.1. UCS1204B:2025 “Хүүхдийн зуслангийн гадна орчинд тавигдах ерөнхий шаардлага” хотын стандартыг нэгдүгээр хавсралтаар;

1.2. UCS1205C:2025 “Нийтийн эх, хүүхдийн өрөөг төлөвлөх гарын авлага хотын стандартыг хоёрдугаар хавсралтаар;

2. Батлагдсан хотын стандартыг олон нийтэд сурталчлан, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Х.Нямбаатар)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолыг 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдсүгэй.


4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бүсчилсэн хөгжлийн хороо (Л.Ариунтуяа)-д даалгасугай.

ДАРГА

А.БАЯР

17.04.2025 36

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн
дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт



ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ГАДНА ОРЧИН

UCS 1204B:2025

“ХҮҮХДИЙН ЗУСЛАНГИЙН ГАДНА ОРЧИНД ТАВИГДАХ ШААРДЛАГА” ХОТЫН СТАНДАРТ

1. ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү стандартыг Нийслэлийн нутаг дэвсгэрт хүүхдийн амралт, зуслангийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж байгууллага, иргэн түүнд хяналт тавих эрх бүхий байгууллага, албан тушаалтан дагаж мөрдөнө.

2. НОРМАТИВ ЭШЛЭЛ

Энэхүү стандартад эш татсан дараах барилгын норм ба дүрэм, стандартын шаардлагыг хангах ба өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлийн эх материалыг үндэслэл болгох гэж өөрчлөн оруулав.

- Нэгдсэн Үндэсний Байгууллага /НҮБ/ Хүүхдийн эрхийн тухай Конвенц;
- НҮБ-ын Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай Олон Улсын хөдөлмөрийн Байгууллагын 182 дугаар Конвенц;
- НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцын Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг нэмэлт протокол;
- Хүүхэд хамгааллын бодлогын жишиг баримт, 2018 он;
- Нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар -Хүүхдийн зуслангийн өнөөгийн байдал, үйлчилгээний чанар хийсэн дүн шинжилгээ, 2019 он;
- MNS 5633:2023. Хүүхдийн зуслангийн үйл ажиллагаа, Ерөнхий шаардлага;
- MNS 42445:44. Галын аюулгүй байдал, Ерөнхий шаардлага;
- MNS ISO 8124-4 Тоглоомын аюулгүй байдал. 4-р хэсэг: Орон сууцны дотор, гадна талд байрлуулан хэрэглэдэг савлуур, гулсуур болон түүнтэй төсөөтэй тоглоомын ажиллагаа;
- БНБД 30-01-04 Хот тосгоны төлөвлөлт, барилгажилт;
- UCS 0901B:2022 Явган хүний зам, талбайн төлөвлөлт, хучилт, угсралтад тавих ерөнхий шаардлага;
- UCS 0902B:2022 Тээврийн хэрэгслийн ил зогсоолыг төлөвлөх, байгуулахад тавих ерөнхий шаардлага;
- UCS 1101B:2022 Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын гадна орчны ерөнхий шаардлага;
- UCS 1404B:2022 Саравч, сүүдрэвчинд тавих ерөнхий шаардлага;
- UCS 1405B:2022 Хүүхдийн тоглоомын талбайн ерөнхий шаардлага;
- UCS 1409B:2022 Чийрэгжүүлэх талбайн төлөвлөлт, тоног төхөөрөмжид тавих ерөнхий шаардлага;

- UCS 1410B:2022 Хашаа, хайс, хашлаганд тавих ерөнхий шаардлага;
- UCS 1604B:2022 Хүүхдийн автобусанд тавих ерөнхий шаардлага;
- UCS 1701A:2022 Хог хаягдлыг цуглуулах, ангилах, хадгалах, тээвэрлэх арга зүйн менежмент;
- UCS 1901B:2022 Гэрэлтүүлгийн тоног төхөөрөмжид тавих ерөнхий шаардлага;
- UCS 1902A:2022 Гэрэлтүүлэх төхөөрөмжийг байрлуулах; суурилуулах технологийн удирдамж.

3. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

Аянга зайлуулагч - гэж аянга цахилгааны идэвхжилийг хүнээс зайлуулж, өөр дээрээ хүлээж авдаг хүлээн авах, дамжуулах, газардуулах гэсэн бүтэцтэй өндөрт байрлах холбогдох стандарт, шаардлагын дагуу тоног төхөөрөмжийг;

Хамгаалалтын зурвас - гэж инженерийн бэлтгэл арга хэмжээний барилга байгууламжийн хэвийн найдвартай үйл ажиллагааг хангах, хамгаалах зорилгоор тодорхой хязгаарлалт тогтоосон газрыг хэлнэ.

4. ХҮҮХДИЙН ЗУСЛАНГИЙН ГАДНА ОРЧНЫ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

4.1. Хүүхдийн зуслан дараах иж бүрдэлтэй байна. Үүнд:

- амрагч хүүхдүүдийн байр;
- чөлөөт цаг өнгөрөөх бүс;
- амралт, үзвэрийн бүс;



ТОДОРХОЙЛОЛТ


- | | |
|--|----------------------------------|
| 1. Гол орц | 8. Хүүхдийн тоглоомын талбай |
| 2. Авто зогсоол | 9. Задгай театр |
| - Хөгжлийн дэрхшээлтэй иргэний зогсоол | 10. Нийтийн дие засах газар |
| - Автобусны зогсоол | 11. Саравч |
| 3. Хүүхдийн зуслангийн гол барилга | 12. Хөшөө /Архитектурын элемент/ |
| 4. Хүүхдүүд байрлах байр | 13. Гүний худаг |
| 5. Галын наадмын талбай | |
| 6. Хогийн цэг | |
| 7. Спорт талбай | |
| - Сагсан бөмбөгийн талбай | |
| - Хөл бөмбөгийн талбай | |
| - Теннисний талбай | |

Зураг 1. Ерөнхий төлөвлөлт (жишээ зураг)

- тоглоомын болон спорт талбай;
- зоогийн газар;
- угаалгын газар;
- тээврийн хэрэгслийн зогсоол;
- хог хаягдал түр хадгалах цэг;
- ариун цэврийн байгууламж;
- бусад шаардлагатай барилга байгууламж.

4.2. Хүүхдийн зуслангийн гадна орчныг төлөвлөхөд дараах шаардлагыг хангуулна.
Үүнд:

- 4.2.1. Хүүхдийн зуслан нь өөрийн эзэмшлийн газартай байна.
- 4.2.2. Хүүхдийн зуслангийн барилга байгууламжийг төлөвлөхдөө байгаль орчны үнэлгээ, инженер геологийн дүгнэлтийг үндэслэн, газарзүйн онцлог байдлыг тодорхойлуулж мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ.
- 4.2.3. Зуслангийн эдэлбэр газар нь хамгаалалтын хашаатай байна.
- 4.2.4. Хүүхдийн зуслангийн гадна орчин нь хүүхдийн аюулгүй байдлыг бүрэн хангасан байна.
- 4.2.5. Зуслангийн гадна орчин, барилга байгууламж нь хөгжлийн бэрхшээлтэй, тусгай хэрэгцээт хүүхдийн биеийн онцлогт тохирсон, хүртээмжтэй байдлыг хангасан байна.
- 4.2.6. Зуслангийн үйл ажиллагааны чиглэлээс хамаарч амрагч хүүхдүүдийн байрыг байшин, гэр, майхан хэлбэрээр төлөвлөж болно.
- 4.2.7. Зуслангийн байрлалыг сонгохдоо усан сан бүхий газар буюу гол, нуур, ойн сан бүхий газраас 200м-ээс дээш зайд төлөвлөнө.
- 4.2.8. Зуслангийн үйлчилгээний болон амрах байр нь гамшгийн үед гарах гарц, хаалга, аваарын шаттай байна.
- 4.2.9. Хүүхдийн зусланд чөлөөт бүс, үзвэрийн талбай, тоглоомын талбай, спорт талбай, ногоон байгууламж зэрэг нь гадна орчинд хамаарах бөгөөд аюулгүй байдлыг хангасан байна.



Зураг 2. Ерөнхий төлөвлөлт харагдах байдал (жишээ зураг)

4.2.10. Гадна тохижилт нь хүүхдийн зуслангийн онцлогийг илэрхийлсэн цэвэр цэмцгэр, өнгө үзэмжтэй, чанар, стандартын шаардлага хангасан, эдэлгээ даах материалаар хийгдсэн байна.

4.2.11. Гадна тохижилтын элементүүдийн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, засвар үйлчилгээг тогтмол хийж гүйцэтгэнэ (Будах, засах, солих, шинээр тохижуулах гэх мэт).


4.2.12. Дотоод зорчих хөдөлгөөний схем зурагтай байна.

4.3. Тээврийн хэрэгслийн авто зогсоол түүнд тавигдах шаардлага

Зуслангийн эзэмшил газарт багтаан тээврийн хэрэгслийн зогсоолыг төлөвлөх ба дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:


4.3.1. Тээврийн хэрэгслийн ил зогсоолыг төлөвлөж байгуулахдаа UCS 0902B “Тээврийн хэрэгслийн ил зогсоолыг төлөвлөх, байгуулахад тавигдах ерөнхий шаардлага”-ыг дагаж мөрдөнө.

4.3.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зориулалтын авто зогсоолыг төлөвлөхдөө 10 автомашины зогсоол тутамд 1 зогсоол ногдохоор тооцож, орц гарцтай хамгийн ойр байхаар төлөвлөнө.



Зураг 3. Тээврийн хэрэгслийн авто зогсоол (жишээ зураг)

4.3.3. Тэргэнцэртэй иргэдийн тээврийн хэрэгслийн зогсоолын дэргэд хүртээмжтэй, нэвтрэх хэсгийн талбайг байгуулна. Уг талбай нь 1.5м-ээс дээш өргөнтэй байна.



Зураг 4. Хүртээмжтэй зогсоолын хэмжээ (жишээ зураг)

4.4. Хүүхдийн тоглоомын талбайд тавигдах шаардлага

- 4.4.1. Хүүхдийн тоглоомын талбайн тохижилт нь Хүүхдийн тоглоомын талбайн ерөнхий шаардлага UCS 1405B:2022 стандартыг хангасан байна.
- 4.4.2. Хүүхдийн тоглоомын тоног хэрэгслүүд нь хүүхдэд аюул учруулахгүй, бэртэж гэмтэхээс сэргийлсэн зориулалтын материалаар хийгдсэн байна. Хүүхдийн тоглоомын талбайг насны ангиллаар тохижуулж санамж байршуулна.



Зураг 5. Хүүхдийн тоглоомын талбайн харагдах байдал (жишээ зураг)

4.5. Спортын талбайд тавигдах шаардлага

- 4.5.1. Спортын талбайг төлөвлөхдөө тухайн эзэмшил газрын хэмжээнээс хамааруулан гүйлтийн тойрог зам төлөвлөх ба спортын талбайг үндсэн харьцааг алдагдуулалгүй, хашаа хайстай, гэрэлтүүлэгтэй байна.
- 4.5.2. Спортын талбайн тохижилт, тоног төхөөрөмж, материал зэрэг нь холбогдох стандартын шаардлага хангасан, цэвэр, өнгө үзэмжтэй байна.
- 4.5.3. Сагсан бөмбөгийн талбайн самбар тогтоох шон, гар бөмбөгийн талбайн торыг тогтоох шонг газарт хөдөлгөөнгүй 0.8м-ээс багагүй гүнд суулган шонгийн гадаргууг зөөлөвч материалаар бүрж үйлчлүүлэгчдийг аюул осолд өртөхөөс сэргийлсэн байна.
- 4.5.4. Аюул, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор тоног төхөөрөмжийн заавар, тэмдэг, тэмдэглэгээг нүдэнд харагдах газар байрлуулна.



Зураг 6. Спортын талбайн харагдах байдал (жишээ зураг)

4.6. Хашаа, хайс, хашлаганд тавигдах шаардлага

Гадна талбайн хашаа хайс нь Хашаа хайс, хашлаганд тавих ерөнхий шаардлага, UCS1410B:2022 стандартыг хангасан, зэврэлтээс хамгаалсан гадаргуутай, зөөж угсрахад хялбар, байгаль, цаг уурын эрс тэс нөхцөлд тэсвэртэй, өнгө үзэмж алдаагүй, эвдэрч гэмтээгүй байна.




Зураг 7. Хүүхдийн зуслангийн хашааны төрөл (жишээ зураг)

4.7. Явган хүний зам

4.7.1. Явган хүний замыг төлөвлөхдөө Иж бүрэн гудамж: “Явган хүний зам, талбайн төлөвлөлт, хучилт, угсралтад тавих шаардлага” UCS 0901B:2022 стандартыг баримтална.

4.7.2. Явган хүний замын төлөвлөлтөд тавих нэмэлт шаардлага Үүнд:

- явган хүний замын гадаргууг тэгшилж хүүхэд унаж бэртэхээргүй тэгш хэмтэй болгоно;
- явган хүний зам, ногоон байгууламжийг тусгаарласан хашлагатай байна;
- явган хүний замын өргөн 1.5 метрээс доошгүй өргөнтэй байна;
- явган хүний замыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан саадгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэн зохион байгуулсан байна;
- явган хүний замын уулзвар хэсэгт зуслангийн дотоод схем зураг болон барилга, байгууламжийн чиглэлийг заасан тэмдэг байрлуулна.




Зураг 8. Дагуу налуу, хөндлөн хэвгий (жишээ зураг)

4.8. Гадна гэрэлтүүлэгт тавигдах шаардлага

4.8.1. Гэрэлтүүлэг нь зуслангийн талбайн гадна, дотоод орчныг бүхэлд нь гэрэлтүүлэх боломжтой “Гэрэлтүүлгийн тоног төхөөрөмжид тавих ерөнхий шаардлага” UCS1901B:2022 стандартын шаардлагыг хангасан байна.

4.8.2. Гэрэлтүүлэгт тавих нэмэлт шаардлагыг тодорхойлов. Үүнд:

- төв гэрэлтүүлгийг орох, гарах хаалга, хашаа болон хайсны 4 талд байрлуулна;
- амрах байр, театр, хоолны байр, нийтийн ариун цэврийн өрөө, халуун ус, гарах хаалга хүртэлх замын дагуу жижиг гэрэлтүүлгээр хангасан байна;
- явган хүний зам дагуух гэрэлтүүлэг нь тусгалын хүчин чадлаас хамааран хоорондын зайг 8 м-ээс багагүй байхаар тооцон байршуулна;
- байгальд ээлтэй байдлаар нарны энерги, салхины эрчим хүчээр цэнэглэгдэх гэрэлтүүлэг хэрэглэж болно.



Зураг 9. Гэрэлтүүлэг хоорондын зай болон гэрлийг суурилуулах (жишээ зураг)



Зураг 10. Гадна гэрэлтүүлгийн харагдах байдал (жишээ зураг)

4.9. Ногоон байгууламж

Ногоон байгууламжийг төлөвлөхдөө цаг уур, хөрсний шинж чанараас хамааруулж зүлэг, цэцэг мод, бут, сөөгийг сонгон тариална. Мод, бут, сөөгийг сонгохдоо өргөсгүй, элдэв хурц үнэргүйг сонгоно.

4.10. Харуул хамгаалалт

4.10.1. Амрагч хүүхдүүдийн аюулгүй байдлыг хангах харуул хамгаалалтын арга хэмжээг 24 цагийн турш хэрэгжүүлнэ. Үүнд: Зуслангийн орох, гарах хэсэгт харуулын посттой байх, нэгдсэн хяналтын камертай байх гэх мэт.

4.10.2. Амрагч хүүхдүүдийн аюулгүй байдлыг хангах “Теле хяналтын системийн техникийн ерөнхий шаардлага” MNS6423:2019 стандартад нийцсэн хяналтын камер байрлуулан болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлнэ.



Зураг 11. Хяналтын камерын дэлгэц (жишээ зураг)



Зураг 12. Хяналтын постын харагдах байдал (жишээ зураг)

5. ХҮҮХДИЙН БАЙРЛАХ БАЙРАНД ТАВИХ ШААРДЛАГА

- 5.1. Зуланд амарч буй хүүхдүүдийн байрны байршлыг өрөөний цонхоор тусах нарны шууд тусгалын үргэлжлэх хамгийн бага хугацааны нийлбэр 3 цаг байхаар тооцож төлөвлөнө.
- 5.2. Хүүхдийн амрах байрны гадна барилга байгууламжийн мэдээллийн самбарыг байршуулсан байна.
- 5.3. Хүүхдийн зуслангийн барилга байгууламжийг эгц налуу болон хөндлөн огтлолын налууг 30% -аас их байршилд байрлуулахыг хориглоно.



Зураг 13. Хүүхдийн байрлах байр (жишээ зураг)

6. НИЙТИЙН АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖ

- 6.1. Нийтийн ариун цэврийн байгууламжийг төлөвлөхдөө ариун цэвэр, эрүүл ахуйн аюулгүй байдал, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд хүртээмжтэй байдлыг хангаж төлөвлөж байгуулна.
- 6.2. Нийтийн ариун цэврийн өрөөний хүчин чадлыг тооцохдоо нийт амрагч хүүхдүүдийн тооны 10 хувьтай тэнцэхээр тооцно.
- 6.3. Нийтийн бие засах өрөөний ханыг ус, чийг, галд тэсвэртэй, цэвэрлэхэд хялбар материалаар хийнэ.
- 6.4. Нийтийн усанд орох газар нь эрэгтэй, эмэгтэй өрөө тусдаа байна.
- 6.5. Эрэгтэй, эмэгтэй өрөөг ялгах таних тэмдэгтэй байх бөгөөд нүдэнд ил харагдахуйц газарт байрлуулж, өдөр шөнийн аль ч цагт танигдахуйц байна.
- 6.6. Байгаль орчинд сөргөөр нөлөөлөх, эрүүл ахуйн шаардлага хангахгүй, хөрс бохирдуулагч нүхэн жорлон ашиглахыг хориглоно.



Зураг 14. Нийтийн ариун цэврийн байгууламжийн харагдах байдал (жишээ зураг)

7. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ АНГИЛАН ЯЛГАЛТ

- 7.1. Үйл ажиллагаанаас гарсан хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах цэгтэй байх бөгөөд тус цэг нь хог хаягдал асгарах, салхиар тарахаас хамгаалсан битүү тагтай, хөрс бохирдуулахаас хамгаалсан ус, чийг үл нэвтрүүлэх материал бүхий суурьтай байна.
- 7.2. Хог хаягдлын түр цэгийг байрлуулахдаа салхины урсгалын доод чигт байрлуулж, салхи шуурганд хөдлөхгүй байхаар тооцоолон байрлуулна.
- 7.3. Хог хаягдал түр хадгалах цэгийг хүүхдийн зуслангийн барилга байгууламжаас 60м-ийн зайтай байрлуулна.
- 7.4. Гурван байр дунд нэгээс багагүй хогийн сав байхаар тооцон байршуулна.



Зураг 15. Хогийн сав (жишээ зураг)



Зураг 16. Хог хаягдал түр хадгалах цэг (жишээ зураг)

8. АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА


- 8.1. Зуслангийн эдэлбэр газарт насанд хүрэгчдэд зориулсан үйлчилгээ, амралт, сувиллын газар, согтууруулах ундаагаар үйлчлэх цэг, салбар нь хүүхдийн амралт, зуслангийн хамгаалалтын бүсээс 500-аас доошгүй метр зайд байрлуулна.
- 8.2. Хүүхдийн зуслангийн бүс нь шатахуун түгээх газраас 2км-ээс доошгүй зайд оршино.
- 8.3. Зуслангийн бүс нутгийн хил хязгаар, аюулгүй байдлын хамгаалалтын цэгийг тогтоож, эзэмшил газар нутгийг холбогдох хуулийн дагуу баталгаажуулна.
- 8.4. Хүүхдийн зуслан нь стандартад заасан галын аюулгүй байдлын шаардлагыг хангасан байх ба гал түймрийн болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх зурагт самбар, аврах гарцын схем зургийг төв хаалганаас нэвтрэн орох хэсэг, амрах хэсэг болон үйлчилгээний байруудад байрлуулна. Үүнд:
 - 8.4.1. Амрагч хүүхдүүдийн байрлах барилга байгууламжийн дотор хаалганд ойр газарт;

- 8.4.2. Гадна нийтийн эзэмшил талбайд нүдэнд харагдахуйц ил газарт;
- 8.4.3. Хашаа, хайсны гадна талд анхааруулах санамжийг байрлуулна;
- 8.4.4. Барилга байгууламжийн цахилгааны утасны бүрэн бүтэн байдал, ашиглалтын шаардлага, аюулгүй ажиллагааг хангасан байна;
- 8.4.5. MNS 5566:2020 “Аж ахуй нэгж, байгууллага, барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм” стандартын дагуу галын аюулаас сэргийлэх багаж хэрэгслийг хүний нүдэнд ил харагдахуйц газар тэмдэг, тэмдэглэгээ хийж байрлуулна;
- 8.4.6. Зориулалтын галын хорыг барилга байгууламжийн давхруудад газраас 1м өндөрт хүний нүдэнд ил харагдахуйц байрлуулна.



Зураг 17. Галын хорыг нүдэнд харагдахуйц газар байрлуулна (жишээ зураг)

- 8.5. Зуслангийн гадна талбайд галын аюулын орц гарцыг БНБД 21-02-02 /Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм, мөн галын аюулгүй байдлын үндсэн дүрмийн 3 дугаар хавсралтад заасан бүрдлийн дагуу тоног төхөөрөмжийг байрлуулан төлөвлөж хэрэгжүүлнэ. Үүнд:
 - 8.5.1. Зуслангийн хашаа 4 зүгт байрласан дор хаяж 4 орц гарцтай байх шаардлагатай.
 - 8.5.2. Орц гарцыг өргөнийг тооцохдоо тухайн зуслангийн хүчин чадлаас хамааруулан өргөнийг 3м-ээс багагүйгээр тооцно.



Зураг 18. Галын аюулгүй байдлыг хангасан байдал галын дохиолол (жишээ зураг)

- 8.6. Цахилгаан үүсгүүрийн түлш, шатахууныг техникийн дүрмийн дагуу хадгалах бөгөөд байгаль орчныг бохирдуулахгүй байх нөхцөлийг хангасан байна.
- 8.7. Зуслангийн галын наадам хийх талбайн нь галд тэсвэртэй суурийн байгууламжтай зориулалтын бэлдсэн талбай байна. Гал түймрийн аюулгүй байдлын тэмдэг тэмдэглэгээг орц гарц бүхий хэсэг, галын наадам хийх талбай, барилга байгууламж бүрийн гадна болон дотор талд хүний нүдэнд харагдахуйц газарт байрлуулна.




Зураг 19. Галын наадам хийх талбай (жишээ зураг)

			
Галын хор байрлуулсан хэсэг	Галын унтраагуур хоолой байрлуулсан хэсэг	Галын дохиолол асаах товчлуур байрлуулсан хэсэг	Гал түймрийн үед яаралтай тусламж дуудах хэсэг

Зураг 20. Галын аюулгүй байдлын тэмдэг тэмдэглэгээ (жишээ зураг)

- 8.8. Амрагч хүүхдүүдэд анхан шатны эмнэлгийн тусламж үзүүлэхэд шаардагдах урьдчилан сэргийлэх хэсэгт яаралтай тусламжийн хайрцаг /шархны лент, хөвөн, бинт, чиг, эмнэлгийн зориулалтын спирт, иод, даралтын аппарат, биеийн халуун хэмжигч, бусад анхан шатны өвчин намдаах эм/ байршуулна.
- 8.9. Амрагч хүүхдүүдэд зориулсан суурин утсыг барилга байгууламжийн дотор болон гадна байрлуулах ба аюулгүй байдлыг хангасан бүхээгтэй байна.



Зураг 21. Бүхээгтэй суурин телефон утас (жишээ зураг)

9. МЭДЭЭЛЛИЙН САМБАР, АНХААРУУЛАХ ТЭМДЭГ, ТЭМДЭГЛЭГЭЭ

Хүүхдийн зуслангийн ойр орчимд байгаль орчинтой зүй зохистой харьцах тухай санамжуудыг байршуулна. Үүнд:




Зураг 22. Мэдээллийн самбар, анхааруулах тэмдэг, тэмдэглэгээ

10. БОХИР УСНЫ ИНЖЕНЕРИЙН БАЙГУУЛАМЖ, ЦЭВЭРЛЭСЭН БОХИР УСАНД ТАВИХ СТАНДАРТ ШААРДЛАГА

- 10.1. Усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүс, усны эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн заагийг тэмдэгжүүлж, бүсийн дэглэмийн хэрэгжилтийг хангаж ажиллана.
- 10.2. Бохир усны шийдэл нь байгаль орчинд сөргөөр нөлөөлөхгүй байхаар хийсэн байна.
- 10.3. Бохир усыг дахин ашиглаж, саарал ус гаргадаг технологийг нэвтрүүлнэ.
- 10.4. Бохир усны цооног нь хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй дараах стандартыг хангасан байна. Үүнд:
- MNS4943:2015 “Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага”;
 - MNS4288:1995 “Бохир ус цэвэрлэх байгууламжуудын байршил, цэвэрлэгээний технологи түвшинд тавих үндсэн шаардлага”;
 - БНБД40-01-06 “Ариутгах татуурга, гадна сүлжээ ба байгууламж”;
 - MNS0900:2018 “Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ”;
 - MNS5924:2015 “Нүхэн жорлон, угаадасны нүх Техникийн шаардлага”.
- 10.5. Бохир усны нүх болон цэвэршүүлэх байгууламжийг барилга байгууламжаас 50м-ээс багагүй зайд салхины доод чигт байрлуулна.

11. ҮЕРЭЭС ХАМГААЛАХ БАЙГУУЛАМЖ БОЛОН ХУР ТУНАДАСНЫ УС ЦУГЛУУЛЖ ҮР АШИГТАЙ ХЭРЭГЛЭХ БАЙГУУЛАМЖ

- 11.1. Тухайн хүүхдийн зуслангийн байршлаас хамааран зохих үерээс хамгаалах арга хэмжээг авсан байх шаардлагатай. Үүнд:
- 11.1.1. Үерээс хамгаалах байгууламжийг батлагдсан зураг төслийн дагуу гүйцэтгэсэн байна.
- 11.1.2. Хур тунадасны ус ихээр цуглардаг цэгүүдийг тогтоож ус зайлуулах суваг, шуудуу зэргийг холбогдох норм дүрмийн дагуу төлөвлөсөн байна.



Зураг 23. Үерээс хамгаалах байгууламж (жишээ зураг)

12. БИЕ ДААСАН ЦАХИЛГААН ХАНГАМЖ

12.1. Хүүхдийн зуслангийн гадна цахилгаан хангамж нь төвийн эрчим хүчний шугамаас хангагдах бөгөөд сэргээгдэх эрчим хүчний тухай хуульд заасны дагуу дараах бие даасан эрчим хүчний эх үүсвэртэй байна.

12.2. Сэргээгдэх цахилгаан эрчим хүчийг доорх эх үүсвэрээс ашиглана. Үүнд:

- нарны эрчим хүч;
- салхины эрчим хүч.

12.3. Гэнэтийн ослын үед ашиглах нөөц цахилгаан үүсгүүртэй байна.

12.4. Эрчим хүчний шугам сүлжээний аюулгүй ажиллагааг хангах хүн амьтан осолдохоос урьдчилан сэргийлэх зорилгоор дэд станц, шугам сүлжээний хамгаалалтын зурвасыг байгуулна.

12.5. Хамгаалалтын зурвасыг байгуулахдаа эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрмийг баримтална. Үүнд:

Хүснэгт 1. Цахилгаан шугам сүлжээний хамгаалалтын бүс

№	Шугам сүлжээний хүчдэлийн түвшин	Хүн оршин суудаггүй газраар өнгөрөх нөхцөлд	Хүн оршин суудаг газраар өнгөрөх нөхцөлд	Дэд станц, хуваарилах байгууламж
		Шугамын захын утаснаас 2 тийш		Бүх тал руугаа
1	Цахилгаан дамжуулах шугам 1кВ хүртэл	-	1-1,5м	-
2	1-20 кВ хүртэл	10м	2м	10м
3	35 кВ хүртэл	15м	4м	15м
4	110 кВ хүртэл	20м	5м	20м
5	220 кВ хүртэл	25м	6м	25м

13. БИЕ ДААСАН УС ХАНГАМЖ


13.1. Ундны усны эх үүсвэр нь MNS 0899:2020 “Унд ахуйн зориулалттай төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрийг сонгох журам ба эрүүл ахуй, техникийн шаардлага”, MNS 0900:2018 “Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ” үндэсний стандартын шаардлагыг хангасан байна.

13.2. Ундны усны эх үүсвэр нь дараах байдлаар байна. Үүнд:

- гүний худаг;
- зөөврийн худаг.

13.3. Гүний худаг нь стандартын шаардлага хангасан эх үүсвэрээс олборлон эзэмшил газарт багтаан эх үүсвэрийг сонгох ба орчны аюулгүй байдал нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- гүний худгийг хүүхдийн зуслангийн барилга байгууламжид байрлуулахыг хориглоно;
- хамгаалалтын бүсийг тогтоож, хашаажуулах;
- мэдээллийн самбар байршуулах;
- камержуулалт
- гэрэлтүүлэг



Зураг 24. Ундны усны эх үүсвэрийг хамгаалахдаа дээрх нөлөөллийг тооцоолох (жишээ зураг)

13.4. Эрүүл ахуйн хамгаалалтын бүс буюу гүний худгийн ойр орчмын 50 м зайд дараах үйл ажиллагааг явуулахыг хориглоно. Үүнд:

- 13.4.1. Газрын өнгөн хөрсийг эвдрэл элэгдэлд оруулах, мод бут огтлох
- 13.4.2. Цэвэрлээгүй бохир усны хаягдал болон хог хаягдал хаях, хогийн цэг байршуулах
- 13.4.3. Хаягдал бохир ус цэвэрлэх байгууламж буюу ариутгах татуургын төвлөрсөн сүлжээнд холбогдоогүй барилга байгууламж барьж ашиглах
- 13.4.4. Стандартын шаардлага хангаагүй ариун цэврийн байгууламж /нүхэн жорлон/ байрлуулах зэрэг багтана.

14. ШАЛГАХ ХУУДАС

Хүүхдийн зуслангийн стандартын шаардлагыг хангаж байгаа эсэх шалгуур үзүүлэлтийг хүснэгтийн дагуу хянаана.

Хүснэгт 2. Шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Тийм	Үгүй
1	Эзэмшил газарт хүүхдийн зуслангийн зориулалтын барилга байгууламжаас бусад төрлийн барилга байгууламж байгаа эсэх	☐	☐
2	Гадна талбай болон барилга байгууламжид гэрэлтүүлэг стандартын дагуу хангалттай тавигдсан эсэх	☐	☐
3	Хүүхэд тээвэрлэх тээврийн хэрэгслийн зориулалтын авто зогсоолтой эсэх	☐	☐
4	Эзэмшил газарт болон барилга байгууламж цахилгаан эрчим хүчний холбогдох байгууламжид аянга зайлуулагч хийгдсэн эсэх	☐	☐
5	Гадна орчинд хяналтын камер шаардлагын дагуу суурилуулсан эсэх	☐	☐
6	Хяналтын посттой эсэх	☐	☐
7	Хотын стандартын дагуу хашаа байрлуулсан эсэх	☐	☐
8	Галын аюулаас хамгаалах тоног төхөөрөмжтэй эсэх	☐	☐
9	Гэнэтийн аваар ослын дохиолол мэдээллийн тоног төхөөрөмж суурилуулсан эсэх	☐	☐
10	Хүүхдүүдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн спорт талбайтай эсэх	☐	☐
11	Стандартад нийцсэн хүүхдийн тоглоомын талбайтай эсэх	☐	☐
12	Бие даасан ариун цэврийн байгууламжийг стандартын дагуу тохижуулсан эсэх	☐	☐
13	Үерийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ тусгасан эсэх	☐	☐
14	Ангилан ялгах хогийн цэгийг шаардлагатай байршлуудад байршуулсан эсэх	☐	☐

Тайлбар: Хүүхдийн зуслангийн гадна орчин нь дээрх бүх шаардлагыг хангаж байх ёстой бөгөөд шаардлага хангасан бол **“Тийм”** хийгдээгүй буюу хийгдсэн боловч шаардлага хангахгүй байгаа бол **“Үгүй”** хэсгийг тэмдэглэнэ.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

- Засгийн газрын 1996 оны 120 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт “Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм”;
- MNS 4244:1994 Хөдөлмөр хамгааллын систем Галын аюулгүй байдал Ерөнхий шаардлага;
- MNS ISO 8124-4 Тоглоомын аюулгүй байдал. 4-р хэсэг: Орон сууцны дотор, гадна талд байрлуулан хэрэглэдэг савлуур, гулсуур болон түүнтэй төсөөтэй тоглоомын ажиллагаа;
- БНБД 30-01-04 Хот тосгоны төлөвлөлт, барилгажилт
- UCS 0901B:2022 Явган хүний зам, талбайн төлөвлөлт, хучилт, угсралтад тавих ерөнхий шаардлага;
- UCS 0902B:2022 Тээврийн хэрэгслийн ил зогсоолыг төлөвлөх, байгуулахад тавих ерөнхий шаардлага;
- UCS 1203B:2022 Амралтын газар, жуулчны баазын гадна болон дотоод орчны тохижилт, зохион байгуулалтад тавих ерөнхий шаардлага;
- <https://sswm.info/content/septic>;
- http://birdsandpowerlines.org/cm/media/Protecting_birds_on_powerlines.pdf;
- https://energy.danube-region.eu/wp-content/uploads/sites/6/sites/6/2019/09/Study_Birds_FIN.pdf.



Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг
ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗАР



Хан-Уул дүүрэг, 23 дугаар хороо, Наадамчдын зам 1201,
Нийслэлийн нутгийн захиргааны цогцолбор Б байр



72707700



www.uds.ub.gov.mn



Хот байгуулалт, хотын стандартын газар